

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/09/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	3
Хүснэгтийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Залруулсан алдаа	22
5.2 Төлбөрийн акт.....	23
5.3 Албан шаардлага	24
5.4 Зөвлөмж	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	27
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	27
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	29

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.....	17
Хүснэгт 2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	18
Хүснэгт 3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 4 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт	18
Хүснэгт 5 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	21

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.20 № 01/63
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Гэрээний урьдчилгаа төлбөр 5,000.0 мянган төгрөгийг бүртгэхдээ өглөг дансанд бүртгэсэн, гэрээг дүгнэж, ажил үйлчилгээг хүлээж аваагүй байхад 3,000.0 мянган төгрөгийг зардал данс руу бичилт хийж хаасан, цалингаас суутгасан 2,160,095.8 мянган төгрөгийн ХХОАТ, НДШ-ийг цалингийн өглөг дансанд, цалингийн урьдчилгааг олгохдоо цалингийн өглөг дансанд бүртгэж цалингийн зардал данс руу хаасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Байр түрээсэлсний орлого 38.5 мянган төгрөгийг төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлж, бүртгэж тайлагнаагүй байна.
- Сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулсан, шийтгэлтэй албан хаагчдад 1,968.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,991,525,543.9	1,460,808,056.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,276,588.5	3,046,298.2
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,276,588.5	3,046,298.2
3121	Төгрөг	6,276,588.5	3,046,298.2
31211	Төрийн сангийн харилцах	5,126,252.5	3,046,298.2
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	1,150,336.0	0.0
33	АВЛАГА	1,007,087,899.7	40,031,012.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	9,505,161.7	4,426,012.0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	997,582,738.0	35,605,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	978,161,055.7	1,417,730,746.2
351	Түүхий эд материал	765,349,713.3	1,145,766,594.7
35110	Тусгай зориулалттай материал	199,618,802.3	229,196,445.5
35130	Эм боох материал	565,730,911.0	916,570,149.2
354	Хангамжийн материал	212,811,342.4	271,964,151.5
35410	Бичиг хэргийн материал	1,308,000.0	1,393,800.0
35420	Аж ахуйн материал	1,489,100.0	2,094,920.0
35430	Сэлбэг хэрэгсэл	0.0	521,000.0
35440	Түлш, шатах тослох материал	0.0	5,349,720.0
35460	Хүнсний материал	3,054,868.0	6,633,493.1
35470	Бусад хангамжийн материал	206,959,374.4	255,971,218.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,034,622,294.6	15,556,673,169.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,034,622,294.6	15,556,673,169.1
392	Биет хөрөнгө	11,344,438,377.9	14,864,556,296.7
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,401,893,779.0	7,777,319,918.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-650,446,467.2	-867,025,439.0
39203	Авто-тээврийн хэрэгсэл	298,193,934.0	455,831,119.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-188,810,658.7	-223,028,280.3
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,070,504,260.9	12,964,332,387.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,734,012,897.7	-5,563,787,362.2
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	242,370,347.1	476,418,167.1
39208	Хуримтлагдсан элэгдэл	-181,811,368.2	-223,813,784.3
39209	Зам, гүүрийн байгууламж	212,268,121.0	212,268,121.0
39210	Хуримтлагдсан элэгдэл	-155,533,484.0	-169,217,143.2
39214	Бусад үндсэн хөрөнгө	64,202,224.0	65,522,224.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-34,784,412.2	-40,668,631.3
39217	Ном	405,000.0	405,000.0
393	Биет бус хөрөнгө	690,183,916.7	692,116,872.4
39301	Програм хангамж	75,399,500.0	77,990,700.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-74,665,583.3	-75,323,827.6
39303	Бусад биет бус хөрөнгө	689,450,000.0	689,450,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,026,147,838.5	17,017,481,225.6

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,059,980,006.5	111,237,584.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,059,980,006.5	111,237,584.6
413	Өглөг	1,059,980,006.5	111,237,584.6
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,059,980,006.5	111,237,584.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,966,167,832.0	16,906,243,641.0
51	Засгийн газрын хувь оролцоо	12,966,167,832.0	16,906,243,641.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,497,859,191.4	4,497,859,191.4
51101	Өмч: - төрийн	4,497,859,191.4	4,497,859,191.4
512	Хуримтлагдсан үр дүн	3,988,447,775.0	7,928,523,584.0
51210	Өмнөх үеийн үр дүн	3,988,447,775.0	3,988,447,775.0
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	3,940,075,809.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,479,860,865.6	4,479,860,865.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,026,147,838.5	17,017,481,225.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,691,628,029.6	16,827,254,018.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,731,230,181.1	6,525,422,294.5
120	Нийтлэг татварын бус орлого	4,731,230,181.1	6,525,422,294.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	125,139,150.0	444,867,160.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	125,139,150.0	444,867,160.0
120009	Бусад орлого	1,995,000.0	0.0
122001	Хандив тусламж /дотоод/	4,604,096,031.1	6,080,555,134.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,960,397,848.5	10,301,831,723.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	591,071,178.0	0.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	133,239,919.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	416,613,000.0	0.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,218,259.0	0.0
1330	Төсвийн захирагчдаас	500,000,000.0	0.0
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	200,000,000.0	0.0
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	300,000,000.0	0.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,869,326,670.5	10,301,831,723.9
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,869,326,670.5	10,301,831,723.9
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,706,889,878.7	12,887,178,209.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,706,889,878.7	12,887,178,209.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,285,469,497.7	12,879,188,403.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,806,547,899.8	5,602,698,901.8
210101	Үндсэн цалин	2,679,387,376.8	3,308,666,523.0
210102	Нэмэгдэл	2,703,179,925.0	1,800,131,161.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	160,598,118.0	152,960,433.0
210104	Урамшуулал	263,382,480.0	339,310,595.0
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	1,630,189.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	770,493,172.9	703,104,358.9
210201	Тэтгэврийн даатгал	544,719,421.9	486,084,759.2
210202	Тэтгэмжийн даатгал	58,720,838.3	56,970,184.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	46,708,511.7	44,834,778.9
210204	Ажилгүйдлийн даатгал	10,886,999.9	10,441,197.0
210205	Эрүүл мэндийн даатгал	109,457,401.2	104,773,439.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	702,992,079.0	768,252,705.8
210301	Гэрэл, цахилгаан	91,960,086.0	97,723,096.0
210302	Түлш, халаалт	443,360,269.0	484,573,796.8
210303	Цэвэр, бохир ус	167,671,724.0	185,955,813.0
2104	Хангамж, бараа материалын зардал	209,334,684.6	275,165,421.3

210401	Бичиг хэрэг	29,182,380.0	42,898,990.0
210402	Тээвэр, шатахуун	80,689,080.0	103,183,280.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,110,339.6	8,949,847.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	79,344,560.0	99,707,308.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,008,325.0	20,425,996.0
2105	Нормативт зардал	3,608,859,008.0	3,164,224,310.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,292,173,272.8	2,913,817,127.1
210502	Хоол, хүнс	307,944,507.2	233,268,382.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,741,228.0	17,138,800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,636,948.0	143,599,878.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,062,950.0	7,088,770.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,499,500.0	3,241,000.0
210604	Урсгал засвар	70,074,498.0	133,270,108.0
2107	Томилолт, зочны зардал	668,000.0	5,472,000.0
210702	Дотоод албан томилолт	668,000.0	5,472,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,730,325.0	70,531,731.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,067,600.0	56,595,750.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,056,500.0	2,844,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	632,025.0	727,650.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.0	790,574.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.0	253,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,556,450.0	7,188,330.0
210807	Газрын төлбөр	1,977,750.0	2,019,927.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.0	112,500.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	220,000.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,041,207,380.3	2,146,139,096.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,743,450.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	985,000.0	3,339,500.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,022,478,930.3	2,142,799,596.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	421,420,381.0	7,989,806.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	421,420,381.0	7,989,806.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	421,420,381.0	7,989,806.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,984,738,151.0	3,940,075,809.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,984,738,151.0	3,940,075,809.0

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	8,363,202,611.5	11,708,676,621.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,474,401.0	444,867,160.0
120	Нийтлэг татварын бус орлого	101,474,401.0	444,867,160.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	92,072,462.0	444,867,160.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	92,072,462.0	444,867,160.0
120009	Бусад орлого	9,401,939.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,261,728,210.5	11,263,809,461.9
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	897,597,460.0	0.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	897,597,460.0	0.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	587,424,278.0	0.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,725,000.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	224,642,828.0	0.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	359,056,450.0	0.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,776,706,472.5	11,263,809,461.9
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,776,706,472.5	11,263,809,461.9
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8,200,178,629.6	11,559,222,956.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,200,178,629.6	11,559,222,956.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,785,843,048.6	11,550,385,150.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,452,421,212.0	5,597,619,752.1
210101	Үндсэн цалин	2,177,517,877.0	3,303,587,373.3
210102	Нэмэгдэл	2,029,996,858.0	1,800,131,161.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	116,173,618.0	152,960,433.0
210104	Урамшуулал	128,732,859.0	339,310,595.0
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	1,630,189.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	568,978,670.9	703,104,358.9
210201	Тэтгэврийн даатгал	399,895,297.6	486,084,759.2
210202	Тэтгэмжийн даатгал	43,887,444.3	56,970,184.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	34,982,916.5	44,834,778.9
210204	Ажилгүйдлийн даатгал	8,160,244.9	10,441,197.0
210205	Эрүүл мэндийн даатгал	82,052,767.5	104,773,439.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	888,252,705.8
210301	Гэрэл, цахилгаан	0.0	97,723,096.0
210302	Түлш, халаалт	0.0	604,573,796.8
210303	Цэвэр, бохир ус	0.0	185,955,813.0
2104	Хангамж, бараа материалын зардал	0.0	271,650,355.3

210401	Бичиг хэрэг	0.0	30,955,390.0
210402	Тээвэр, шатахуун	0.0	108,553,350.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,110,339.6	8,949,847.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	79,344,560.0	40,723,748.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,008,325.0	82,468,020.0
2105	Нормативт зардал	1,697,299,307.0	3,802,769,469.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,380,613,571.8	3,523,737,511.0
210502	Хоол, хүнс	307,944,507.2	236,812,508.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,741,228.0	42,219,450.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,990,818.0	189,091,218.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,062,950.0	61,302,430.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.0	1,722,000.0
210604	Урсгал засвар	70,428,368.0	126,066,788.0
2107	Томилолт, зочны зардал	668,000.0	5,472,000.0
210702	Дотоод албан томилолт	668,000.0	5,472,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,730,325.0	87,755,791.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,067,600.0	58,305,450.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,056,500.0	2,844,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	632,025.0	727,650.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.0	790,574.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.0	253,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,556,450.0	13,282,330.0
210807	Газрын төлбөр	1,977,750.0	2,019,927.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.0	112,500.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	220,000.0	9,420,360.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	190,914,932.0	4,669,500.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	189,929,932.0	1,330,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.0	3,339,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	414,335,581.0	8,837,806.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	414,335,581.0	8,837,806.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	414,335,581.0	8,837,806.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	163,023,981.9	149,453,665.8
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.0	152,683,956.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	152,683,956.0
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	152,683,956.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.0	152,683,956.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	163,023,981.9	-3,230,290.2
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	6,276,588.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	161,621,213.9	3,046,298.2

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.4	4,479,860,865.6	1,166,882,791.8	10,144,602,848.8
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,497,859,191.4	4,479,860,865.6	1,166,882,791.8	10,144,602,848.8
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(185,101,049.3)	(185,101,049.3)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.4	4,479,860,865.6	3,988,447,775.0	12,966,167,832.0
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.4	4,479,860,865.6	3,988,447,775.0	12,966,167,832.0
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,497,859,191.4	4,479,860,865.6	3,988,447,775.0	12,966,167,832.0
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	3,940,075,809.0	3,940,075,809.0
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.4	4,479,860,865.6	7,928,523,584.0	16,906,243,641.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,721,877,200.00	11,711,906,912.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,721,877,200.00	11,711,906,912.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,713,037,200.00	11,703,069,106.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,275,520,200.00	5,597,619,752.08
210101	Үндсэн цалин	3,228,867,400.00	3,303,587,373.28
210102	Нэмэгдэл	2,173,373,800.00	1,800,131,161.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	231,471,900.00	152,960,433.00
210104	Урамшуулал	641,807,100.00	339,310,595.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	1,630,189.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	809,440,100.00	703,104,358.93
210201	Тэтгэврийн даатгал	550,419,300.00	486,084,759.21
210202	Тэтгэмжийн даатгал	64,755,200.00	56,970,184.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	51,804,200.00	44,834,778.90
210204	Ажилгүйдлийн даатгал	12,951,000.00	10,441,197.04
210205	Эрүүл мэндийн даатгал	129,510,400.00	104,773,439.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	900,160,600.00	888,252,705.80
210301	Гэрэл, цахилгаан	120,687,500.00	97,723,096.00
210302	Түлш, халаалт	580,050,000.00	604,573,796.80
210303	Цэвэр, бохир ус	199,423,100.00	185,955,813.00
2104	Хангамж, бараа материалын зардал	275,051,900.00	275,041,345.30
210401	Бичиг хэрэг	25,983,200.00	30,955,390.00
210402	Тээвэр, шатахуун	122,156,700.00	108,553,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,576,000.00	8,949,847.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	63,435,800.00	40,723,748.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	52,900,200.00	85,859,010.00
2105	Нормативт зардал	3,953,032,800.00	3,802,769,469.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,618,734,800.00	3,523,737,511.03
210502	Хоол, хүнс	280,858,000.00	236,812,508.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	53,440,000.00	42,219,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	344,384,500.00	325,497,074.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	178,135,000.00	178,045,669.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,850,000.00	1,722,000.00
210604	Урсгал засвар	160,399,500.00	145,729,405.00
2107	Томилолт, зочны зардал	7,951,000.00	5,472,000.00
210702	Дотоод албан томилолт	7,951,000.00	5,472,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	136,521,100.00	98,072,901.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	72,010,600.00	59,625,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,294,000.00	2,844,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	727,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	892,000.00	790,574.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	356,000.00	253,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,594,800.00	22,279,440.00
210807	Газрын төлбөр	6,029,600.00	2,019,927.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,300,000.00	112,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,044,100.00	9,420,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,975,000.00	7,239,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,900,000.00	3,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,075,000.00	3,339,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8840000	8837806
2132	Бусад урсгал шилжүүлэг	8840000	8837806
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8840000	8837806
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12721877200	11709826958
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС	12,294,128,500.00	11,263,809,461.90

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,294,128,500.00	11,263,809,461.90
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	427,748,700.00	446,017,496.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	427,748,700.00	446,017,496.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	5,126,252.47
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	3,046,298.23

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 13 тасаг, 318 эмч, эмнэлгийн ажилтантайгаар үйл ажиллагаа үзүүлдэг. Сүүлийн 5 жилийн дунджаар жилд амбулаториор 114,530 хүнийг үзэж, эмнэл зүйн лабораторийн шинжилгээг 137,706 хүнд хийж, 7000 хүнийг хэвтүүлэн эмчилсэн. Түргэн тусламжийн төвийн дуудлагаар 6,995 хүнд, алсын дуудлагаар 312 удаа сумдад үйлчилж байна.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь хэвтэн эмчлүүлэх 9 тасаг, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, түргэн тусламж, лаборатори, амбулатори, удирдлага санхүү, статистик мэдээлэл, дэмжих үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 13 тасаг, бүтцийг жил бүр оны эхний Нэгдсэн эмнэлгийн даргын тушаалаар батлуулан мөрдлөг болгон ажиллаж байна. Аймгийн нэгдсэн эмнэлэг нь 27 сум, 97 багийн суурин 90.0 мянга, явуулын 20.0 мянга орчим хүн амд 20 орчим төрлийн үндсэн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг ЭМС-ын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Нэгдсэн эмнэлгийн цахим бүртгэлийн хэсгээр болон утсаар үзлэгийн цагаа сонгон цаг товлож эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай авах боломжтой. Амбулаторийн кабинетууд 2022 онд шинээр суурин болон зөөврийн эхо, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, нүдний кабинетад шаардлагатай багаж тоног төхөөрөмжүүд, ясны сийрэгжилт үзэх аппарат, тархины доплер, уян дурангийн иж бүрдэл, компьютер томограф, чих хамар хоолойн кабинетад шаардлагатай багаж тоног төхөөрөмжүүд зэрэг багаж тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдэж үйл ажиллагаагаа явуулсан байна.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 бүлэг, 7 зорилт, 78 дэд зорилттой, хавсралт 1-ээр "Зохион байгуулах сургалтын төлөвлөгөө", хавсралт 2-оор "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө"-г баталсан байна. Жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээ тус байгууллага 77 ажлыг 100 хувь, 1 ажлыг 95 хувьтай гүйцэтгэсэн гэж дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийг 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ээс шинээр мөрдөгдөж эхэлсэн,
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ээс шинээр мөрдөгдөж эхэлсэн,
- Эрүүл мэндийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль

тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2020 оны 6 дугаар сарын 19-ний а/52 тоот тушаалаар "Дотоод аудит хийх журам" батлуулсан, мөрдөн ажиллаж байна.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналт шалгалтын комисс нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 16 арга хэмжээг улирлаар төлөвлөн захиргаа, төсөв санхүү, албаны үйл ажиллагаанд хийж 2 чиглэлээр зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

2022 оны 4 дүгээр сарын 19-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээний мэргэжилтэн Д.Бадамсүрэн, Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Ариунбаяр нар дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулсан байна. Дотоод хяналтын ажлын хэсгийн гишүүн төрөх тасгийн ахлах сувилагч Т.Бурмаа, сүрьеэ тасгийн зөвлөх эмч О.Оюунтүлхүүр нар улсын нэгдүгээр төв эмнэлэгт туршлага судлан ажиллаж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/203 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж эхэлсэн байна. Энэхүү баримт бичигт байгууллагын онцлог бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,991,333.4 мянган төгрөгөөр буюу 21,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,276.6	3,046.3	(3,230.3)
Авлага	1,007,087.9	40,031.0	(967,056.9)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	978,161.1	1,417,730.7	439,569.7
Үндсэн хөрөнгө	12,034,622.3	15,556,673.2	3,522,050.9
Нийт хөрөнгө	14,026,147.8	17,017,481.2	2,991,333.4
Өр төлбөр	1,059,980.0	111,237.6	(948,742.4)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	12,966,167.8	16,906,243.6	3,940,075.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	14,026,147.8	17,017,481.2	2,991,333.4

2022 оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,126.2 мянган төгрөг байсан ба тайлант хугацаанд төрийн сангийн 100140020002 тоот дансанд 11,709,826.9 мянган төгрөгийн орлогын гүйцэтгэл авч 11,711,906.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг хийж 3,046.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй байна

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар ЭМД-ын сангаас 997,582.7 мянган төгрөгийн авлага, НДХ-ээс ажиллагсадтай холбогдсон авлага 9,505.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг 100% барагдуулсан. 2022 онд төлбөртэй үйлчилгээний авлага 40,031.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага дансанд бүртгэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө данс 2022 онд барилга байгууламж, орон сууц 375,426.0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл 157,637.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 4,893,828.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 145,255.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,518.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,320.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 2,591.0 мянган төгрөгийн программ хангамж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 375,426.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 157,637.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 4,748,573.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 4,748,573.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 16,906,244.0 мянган төгрөг болж 3,940,076.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг Эрүүл мэндийн даатгалаас 11,577,700.0 мянган төгрөг, байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 207,800.0 мянган төгрөг гэж тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс бууруулахгүйгээр 2022 оны эхэнд тус байгууллагын төсвийг 11,785,500.0 мянган төгрөгөөр баталсан. ЭМЯ-аас тухайн

эмнэлгийн хүсэлтийн дагуу 2 удаа тодотгон нийт төсөв 12,721,800.0 мянган төгрөг болсон байна. Энэ нь өмнөх оны ЭМД-аас авах авлагыг төсвийн хуваарьт нэмж оруулан ЭМД-аас авсан. Мөн 2022 онд БШУЯ болон ЭМЯ-ны хамтарсан Сайдын тушаал гарч багш нарын урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог зохион байгуулан ажиллаж байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор тодотгол хийлгэж үндсэн үйл ажиллагааны орлого 422,100.0 мянган төгрөгөөр батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалын сангаас 12,294,128.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 427,748.7 мянган төгрөг нийт 12,721,877.2 мянган төгрөг санхүүжихээр батлагдсан. Үүнээс: Эрүүл мэндийн даатгалын сангаас 11,263,809.4 мянган төгрөг (91.6%), Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 446,017.5 мянган төгрөг (104.3%) нийт 11,709,826.9 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн 100140020002 тоот дансанд бүртгэн авч тайлагнажээ. Нийт орлогын бүрдүүлэлтээс 11,711,906.9 мянган төгрөгийн зарлагын гүйцэтгэл хийж бүртгэл хөтлөн 2022 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар төрийн сангийн 100140020002 тоот дансанд 3,046.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй дансны хаалтыг хийсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг үндсэн санхүүжилтийн дансанд шилжүүлж урсгал болон нэмэлт гэсэн 2 данстай байсныг нэг данстай болгосон байна.

Хүснэгт 2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эмнэлгийн тусламж үйлчилгээ -Үндсэн үйл ажиллагааны зардал	12,707,349.7	11,697,381.6	1,009,968.1	92,1
2	Эмнэлгийн тусламж үйлчилгээ - Ажил олгогчоос олгох тэтгэмж	8,840.0	8,840.0		100,0
3	Эмнэлгийн тусламж үйлчилгээ - Олон улсын байгууллагаас олгосон	5,687.5	5,687.5		100,0
	Дүн	12,721,877.2	11,711,906.9	1,009,968.1	92,1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71602 80101	2022.01.01-2022.12.31	Үндсэн үйл ажиллагаа	Үндсэн үйл ажиллагаа 92,1	12,707,349.7	11,697,381.6
2	71602 80202	2022.01.01-2022.12.31	Ажил олгогчоос олгох тэтгэмж	Ажил олгогчоос олгох тэтгэмж 100	8,840.0	8,840.0

3	71602 83601	2022.01.01- 2022.12.31	ОУБ-аас олгосон	ОУБ-аас олгосон 100	5,687.5	5,687.5
---	----------------	---------------------------	--------------------	------------------------	---------	---------

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн нийгмийн хамгааллын дэмжих хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдад тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмжийг гүйцэтгэлд суурилан санхүүжилтийн хүсэлтийг холбогдох материалын хамт албан бичгээр хүргүүлэн олгогдож байсантай холбоотой байна.

Байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдад 98 орон тоогоор батлагдсан байна.

Хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлтийн олон нийтийн зард мэдээлэл хүргэн албан хаагчдыг сонгон шалгаруулалт хийж төрийн үйлчилгээний албан хаагчдын боловсон хүчний асуудлыг шийдвэрлэж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 01/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн, суурь үзүүлэлтийг нийт орлого 1,541,104.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 23,116.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 18,493.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь тайлант онд төсвийн хэмнэлтийн талаарх ЭМЯ-аас өгсөн чиглэлийн дагуу гэрэл цахилгаан, түлш халаалт, урсгал засвар, шуудан холбоо интернэтийн зардал, дотоод томилолтын зардлуудыг бууруулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 100 хувьтай, 5.0 саяас дээших орлогын 39 гүйлгээ, зарлагын 251 гүйлгээ, 5.0 саяас дээших

худалдан авалттай холбоотой 21 гүйлгээг хугацаандаа байршуулахаас 2 сард 5.0 сая төгрөгөөс дээш 8 гүйлгээг хугацаа хоцроосон байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд аудитын урьдчилсан болон төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэж, байгууллагын мөрдөж ажилладаг хууль тогтоомжийн хэрэгжилт, ирсэн явсан бичиг, даргын тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцаж эрсдэлээ тодорхойлсон.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/64 дугаарын албан бичгээр ирүүлсэн.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	536,933.9	1	536,933.9	100
Зөвлөмж					100
Нийт дүн	1	536,933.9	1	536,933.9	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн түрээсийн орлого, хүнс, эмийн материалын зарцуулалтыг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 16,681,280.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 12,478,632.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

Тус байгууллага тайлант онд ХААН банк дахь харилцах дансны орлого, зарлагын 6,118.2 мянган төгрөгийг тайлагнаагүй, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжсэн 10,301,831.7 мянган төгрөгийн орлогыг сангийн яамны И тайланд татаас санхүүжилтийн орлогоор тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Гэрээний урьдчилгаа төлбөр 5,000.0 мянган төгрөгийг бүртгэхдээ өглөг дансанд бүртгэсэн, гэрээг дүгнэж, ажил үйлчилгээг хүлээж аваагүй байхад 3,000.0 мянган төгрөгийг зардал данс руу бичилт хийж хаасан, цалингаас суутгасан 2,160,095.8 мянган төгрөгийн ХХОАТ, НДШ-ийг цалингийн өглөг дансанд, цалингийн урьдчилгааг олгохдоо цалингийн өглөг дансанд бүртгэж цалингийн зардал данс руу хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Тайлант онд 5,500.0 мянган төгрөгийн өртөгтэй шинээр нэмэгдсэн 5 үндсэн хөрөнгөнд 114.5 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй байна. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Дансны заавар”-ын “Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэл”-ийн 4.35-д “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө.” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Дарга үүрэгт ажлаа хэрхэн биелүүлсэн хэдэн хувиар өгөх шийдвэр болон хаасан огноо байхгүй томилолтын хуудсаар томилолт олгохдоо тухай бүр бүртгэлд тусгадаггүй олгосон өдөр бөөн дүнгээр ажиллагсдаас авах авлага дансанд 4976.0 мянган төгрөг, байгууллагад өгөх өглөг дансанд 496.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 4,202,648.0 мянган төгрөгийн илэрсэн зөрчилд² 3,350,290.2 мянган төгрөгийн зөвлөмж, 2,007.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, 850,350.5 мянган төгрөгийн албан шаардлага өглөө.

5.2 Төлбөрийн акт

Байр түрээсэлсний орлого 38.5 мянган төгрөгийг төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлж, бүртгэж тайлагнаагүй зөрчил илэрлээ. Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-д “төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулсан, шийтгэлтэй албан хаагчдад 1,968.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим”, МУ-ын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох тухай” журмын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн 833,373.9 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Зураг төсөвгүй 10,580.0 мянган төгрөгийн ажлыг бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн, ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй, ажил хүлээн авсан комиссын акт үйлдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д “Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Хүүхдээ асарч буй эхийн чөлөөтэй байх хугацааны НДШ-ийг ажил олгогч төлж тайлагнаагүй зөрчилд НД-ын улсын байцаагчийн тавьсан актын алданги 86.8 мянган төгрөгийг төсвөөс төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад сэлбэг хэрэгсэл 521.0 мянган төгрөг, ном 405.0 мянган төгрөг,

програм хангамж 2,080.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Тушаалаар томилогдсон тооллогын комисст тооцооны нягтлан бодогчийг оруулсан, комисс нь тооллого хийсэн гэх боловч тооцоо бодоогүй, илтгэх хуудас дүгнэлт гаргаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Сургалтын үйл ажиллагаанд зориулан хэрэглэгдэхүүн худалдаж авахаар харилцагч байгууллагаас 503.8 мянган төгрөгийн бараа материалыг дансанд орлого авалгүй зардал данс руу хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Төв ньус ХХК-тай байгуулсан гэрээний төлбөр 100.0 мянган төгрөгийг 2021 онд дутуу шилжүүлсэнг өглөгөөр тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Эмнэлгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/94 дугаарын тушаалаар ажилчин, албан хаагчдын дунд 2,700.0 мянган төгрөгийн шагналын сантай "Эелдэг байж-итгэл төрүүлэе" болзолт уралдаан зохион байгуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн

тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3,349,090.2 мянган төгрөгийн өртгөтэй 791 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7-д "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгах, ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах.

2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Төв ньюс ХХК-тай байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх зорилготой 1,200.0 мянган төгрөгийн гэрээг 2022 оны 01 сарын 05-ны өдөр байгуулж төлбөрийг төлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дагаж мөрдөх, шаардлагатай мэдээ мэдээллийг Аймгийн Засаг даргын хэвэл мэдээллийн албаар дамжуулан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн сангийн харилцах данснаас ХААН банкны 5721851275 дугаарын дансанд шилжүүлсэн гүйлгээг арилжааны банкны харилцах дансанд 6,118.2 мянган төгрөг үүнээс кассын дансанд 3,231.0 мянган төгрөгийн орлого зарлагыг бүртгээгүй	1	6,118.2	1	6,118.2			1	6118.2
Гэрээний урьдчилгаа төлбөр 5000.0 мянган төгрөгийг бүртгэхдээ өглөг дансанд бүртгэсэн, гэрээг дүгнэж, ажил үйлчилгээг хүлээж аваагүй байхад 3000.0 мянган төгрөгийг зардал данс руу бичилт хийж хаасан байна.	1	5,000.0			1	5,000.0	1	5,000.0
Дарга үүрэгт ажлаа хэрхэн биелүүлсэн хэдэн хувиар өгөх шийдвэр болон хаасан огноо байхгүй томилолтын хуудсаар томилолт олгохдоо тухай бүр бүртгэлд тусгадаггүй олгосон өдөр бөөн дүнгээр ажиллагсдаас авах авлага дансанд 4976.0 мянган төгрөг, байгууллагад өгөх өглөг дансанд	1	4,976.0			1	4,976.0	1	4,976.0

496.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.								
Тайлант онд 5,500.0 мянган төгрөгийн өртөгтэй шинээр нэмэгдсэн 5 үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй байна.	1	114.6			1	114.6	1	114.6
Цалингаас суутгасан ХХОАТ, НДШ-ийг цалингийн өглөг дансанд, цалингийн урьдчилгааг олгохдоо цалингийн өглөг дансанд бүртгэж цалингийн зардал данс руу хаасан.	1	2,160,095.8			1	2,160,095.8	1	2,160,095.8
Томилолтыг хаасан тухай бүр бүртгэдэггүй, бодож олгохдоо байгууллагад өгөх өглөг дансанд бүртгэсэн	1	496.0			1	496.0	1	496.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжсэн орлогыг сангийн ямны И тайланд татаас санхүүжилтийн орлогоор тайлагнасан	1	10,301,831.7			1	10,301,831.7	1	10,301,831.7
Дүн	7	12,478,632.3	1	6,118.2	6	12,472,514.1	7	12,478,632.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулганы дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байна.	833,373.9	-	833,373.9	-
Зураг төсөвгүй ажлыг бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн, ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй, ажил хүлээн авсан комиссын акт үйлдээгүй байна.	10,580.0	-	10,580.0	-
Хүүхдээ асарч буй эхийн чөлөөтэй байх хугацааны НДШ-ийг ажил олгогч төлж тайлагнаагүй зөрчилд НД-ын улсын байцаагчийн тавьсан актын алдангийг төсвөөс төлсөн	86.8	-	86.8	-
Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад сэлбэг хэрэгсэл 521.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Тушаалаар томилогдсон тооллогын комисст тооцооны нягтлан бодогчийг оруулсан, комисс нь тооллого хийсэн гэх боловч тооцоо бодоогүй, илтгэх хуудас дүгнэлт гаргаагүй байна.	521.0	-	521.0	-
Сургалтын үйл ажиллагаанд зориулан хэрэглэгдэхүүн худалдаж авахаар харилцагч байгууллага руу шилжүүлж бараа материал дансанд орлого авалгүй зардал данс руу хаасан байна.	503.8	-	503.8	-
Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад ном 405.0 мянган төгрөг, программ хангамж 2,080.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Тушаалаар томилогдсон тооллогын комисст тооцооны нягтлан бодогчийг оруулсан, комисс нь тооллого хийсэн гэх боловч тооцоо бодоогүй, илтгэх хуудас дүгнэлт гаргаагүй байна.	2,485.0	-	2,485.0	-
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3,349,090.2 мянган төгрөгийн өртөгтэй 791 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	3,349,090.2	-	-	3,349,090.2

Төв нь юс ХХК-тай байгуулсан гэрээний төлбөр 100.0 мянган төгрөгийг 2021 онд дутуу шилжүүлснийг өглөгөөр тайлагнаагүй байна.	100.0	-	100.0	-
Байр түрээсэлсний орлогыг бүртгэж тайлагнаагүй.	38.5	38.5	-	-
Эмнэлгийн даргын 2022.12.16-ны өдрийн А/94 дугаарын тушаалаар Ажилчин, албан хаагчдын дунд 2700.0 мянган төгрөгийн шагналын сантай "Эелдэг байж-итгэл төрүүлье" болзолт уралдаан зохион байгуулсан байна.	2,700.0	-	2,700.0	-
Сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулсан, шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон	1,968.8	1,968.8	-	-
Төв нь юс ХХК-тай байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх зорилготой гэрээг 2022.01.05-ны өдөр байгуулж төлбөрийг төлсөн байна.	1,200.0	-	-	1,200.0
Дүн	4,202,648.0	2,007.3	850,350.5	3,350,290.2